

АРДЧИЛЛЫН ҮНЭТ ЗҮЙЛС МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Нийгэм судлал 10-р анги

II улирал.

[Email: D.Urantsetseg@must.mn](mailto:D.Urantsetseg@must.mn)

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Монгол улсын үндсэн хуульд ардчиллын үнэт зүйлс хэрхэн туссан, хэрэгжилт нь ямар байгаа талаар баримт тохиолдол онолын үзэл баримтлалд тулгуурлан тодруулах.
- Нийгмийн амьдралтай холбон тайлбарлах, жишээ гаргах, тодорхой арга хэрэглэн харьцуулах.
- Ардчиллын үнэт зүйлсийг жишээ, тохиолдол шинжлэх явцдаа сурагчдаар бие даан, өөрсдөөр нь судлуулах, бусадтай хамтран ярилцах боломжийг бүрдүүлэх.

ТУЛГУУР ОЙЛГОЛТ


- Монголын Ардчилсан Холбоо МоАХ нь 1989 оны ардчилсан хувьсгалыг удирдан зохион байгуулсан улс төрийн хөдөлгөөн юм
- Ардчилал нь демократ гэх ба энэ нь эртний грек хэлний "ард түмэн" (демос, δημος), "засаглал" (кратос, κρατος) гэсэн хоёр хэллэгээс гаралтай үг бөгөөд "ард түмний засаглал" гэсэн утгатай болно.
- Анхны Үндсэн хууль 1924 оны 11 дүгээр сарын 26-нд баталсан.
- 1940, 1960 онуудад тус тус Үндсэн хуулийг шинэчлэн баталж байжээ.
- Шинэ Үндсэн хууль нь 1992 оны 1 сарын 13-нд батлагдсан.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИУД


- Анхны Үндсэн хууль 1924 оны 11 дүгээр сарын 26-нд батлагдсан. 1911-1921 **Хаант улсыг халж Бүгд Найрамдах улсыг тунхагласанаараа түүхэн онцлогтой.**
- Социализмын он жилүүдэд тогтолцооны хувьд эрс өөрчлөлтүүдийг хийх зорилтуудаас шалтгаалж 1940, 1960 онуудад тус тус Үндсэн хуулийг шинэчлэн баталсан Өөрчилсэн юм. 1
- Шинэ Үндсэн хууль 1992 оны 1 сарын 13-нд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаар батлагдсан. (6 бүлэг, 70 зүйлтэй)
- Монгол улсад зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан нийгмийг бүтээн байгуулах тогтолцооны үндсийг энэ хууль тавьж өгчээ. Шинэ Үндсэн хууль нь парламентын засаглалтай бүгд найрамдах улсыг бий болгож, шашин шүтэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хүний эрх зэргийг хуульчлан хамгаалжээ.

ЭРТНИЙ ГРЕК, РОМД ХҮН АМАА ЭД ХӨРӨНГӨӨР НЬ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЖ БАЙЖЭЭ.

Эртний Ромд хүн амаа газар
эзэмшлийн хэмжээгээр нь
хуваасан. 20 югер = 5,0 га



Эртний Грект Дээд анги 500
медимнээс багагүй орлоготой.
1 медимн нь =52,5л,1л=0,86 кг үр



Ардчилал-
ард түмний
удирдлага
юм.

Ардчиллын
зарчим

Нээлттэй

Шударга байх

Хууль дээдлэх

Цөөнхийг
хүндэтгэх

Зөвшилцлийн

Ардчиллын
хэлбэрүүд

Шууд

Төлөөллийн

АРДЧИЛЛЫН ҮНЭТ ЗҮЙЛС

- 1.Иргэдийн улс төрийн оролцоо
- 2.Тэгш эрх
- 3.Тогтмол,чөлөөт шударга сонгууль
4. Нийтэд тайлагнах ил тод байх
- 5.Хүний эрх,эрх чөлөө
6. Олон намын тогтолцоо
- 7.Хуулийн засаглал бие даасан хараат бус байна
- 8.Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих
- 9.Боловсрол

Эх сурвалжтай ажиллах дасгал-1 **12.10 ХЭТТ**

Эх сурвалж: Яагаад ардчилал гэж... Иргэний боловсрол төв УБ 1992

1989 оны арванхоёрдугаар сарын 10-нд Монголын Ардчилсан Холбоо байгуулагдаж ерөнхий зохицуулагчаараа Санжаасүрэнгийн Зоригийг сонгож, анхны цуглаанаа Хүүхэд Залуучуудын Соёлын Төвийн үүдэнд зохион байгуулснаар Монголд ардчилсан хувьсгал эхэлсэн юм. Тус цуглаан дээр МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчоо, Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохийг шаардсан 13 зүйлтэй “Өргөн барих бичиг”-ийг ард олонд уншиж танилцуулжээ.

Асуулт 1. Яагаад Олон улсын хүний эрхийн өдрөөр жагссан бэ?

Асуулт 2. Тухайн цаг үед жагсаал зохион байгуулах боломжтой байсан уу?

Эх сурвалжтай ажиллах дасгал-2

Сурах бичгийн 103-р хуудсыг уншаад дараах асуултанд хариулж бичээрэй.

Үндсэн хуулийн заалтууд	Ижил тал	Ялгаатай тал	Миний дүгнэлт
1960 оны Үндсэн хуулийн 81-р зүйл 1990 оны Үндсэн хуулийн 16,9-р зүйл			
1960 оны Үндсэн хуулийн 82-р зүйл 1990 оны Үндсэн хуулийн 16,10-р зүйл			

ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Эх сурвалжтай ажиллах дасгал 1,2-г дэвтэртээ хийгээрэй.
2. “Монгол дахь ардчилал” эсээ бичих